



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2017 оны 11 сарын 23 өдөр

Дугаар A/475

Улаанбаатар хот

Г

Г

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд тусгагдсан төсөл, арга хэмжээний хүрээнд батлагдсан Эрүүл мэндийн сайдын 2017 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн "Жагсаалт батлах тухай" А/418 дугаар тушаалын 4. Харьяа эрүүл мэндийн байгууллагуудын их засвар жагсаалт /2017 оны тодотгол/-ын 10. Хавдар судлалын үндэсний төвийн дэд өртөө, тасаг хоорондын дулаан алдагдал, өргөтгөлийн дээрийн засварын ажил 163,134,281 /нэг зуун жаран гурван сая нэг зуун гучин дөрвөн мянга хоёр зуун наян нэгэн/ төгрөгийн төсвийг зарцуулах эрх /гэрээ байгуулах, сунгах, цуцлах, хяналт тавих, санхүүжүүлэх/-ийг Хавдар судлалын үндэсний төвийн дарга /Ж.Чинбүрэн/-д шилжүүлсүгэй.

2. Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулан, ажлын гүйцэтгэлийг тайлагнаж ажиллахыг Хавдар судлалын үндэсний төвийн дарга /Ж.Чинбүрэн/-д даалгасугай.

3. Эрх шилжүүлсэнтэй холбогдуулан ажлын гүйцэтгэл, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Д.Очирбат/-д даалгасугай.

САЙД

Д.САРАНГЭРЭЛ



081534